

**2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2024 оны 04 дүгээр сарын 17-ны “Лхагва” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Дүүргийн нутаг дэвсгэрт барилгын суурийн нүх ухсан байршлуудын нарийвчилсан судалгааг гаргаж Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-д хүргүүлэх.	ТХҮХ, ГЗБА
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдээгүй бүх ажлын жагсаалтыг гаргаж, шийдвэрлэх.	СТСХ, ХААА
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаар 04 дүгээр сард багтаан хэлэлцүүлэг зохион байгуулах тул идэвхтэй оролцох.	ХААА
4	Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажлын зураг төслийн ажлын даалгаврыг яаралтай дуусгаж, ажлаа эрчимжүүлэх.	ТХҮХ, ХААА
5	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дүүрэгт ажиллахтай холбогдуулан танилцуулах танилцуулга бэлтгэх.	ЗДТГ, ААНБ-ууд
6	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн дагуу хууль тогтоомж, хотын стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр ажлаа эрчимжүүлж ажиллах. Үүнд: (Иргэний ахуйн зориулалтаар эзэмшсэн газраа зориулалтын бусаар ашиглах, стандартын бусаар эзэмших, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд ашиглахгүй тээврийн хэрэгсэл, эд хөрөнгөө байршуулах г.м)	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, Цагдаагийн хэлтэс, ГЗБА
7	Дүүргийн хүн амын хаврын улирлын махны хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үнийн хөөргөдлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.	ТХҮХ
8	Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хүнсний шинэ бүтээгдэхүүн бий болгох чиглэлээр зээл олгох санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдах тул уялдаатай ажиллах. /Гахай, тахиа, хүлэмжийн аж ахуй гэх мэт/	ТХҮХ
9	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах” өдөр буюу 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хүүхдийн тоглоомын талбайн стандартын хэрэгжилтийг хангуулж, засварлах, шинэчлэх ажлуудаа шуурхай зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Холбогдох ажлын хэсэг
10	Үерээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд мэдээлэх, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах түр төлөвлөгөө, төсвийг боловсруулж танилцуулах.	ТХҮХ, ОБХ, ДОК
11	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлуудад техникийн нөхцөл, зөвшөөрөл олгох ажлыг шуурхайлах.	Холбогдох байгууллагууд
12	“Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн	НХХ,

	тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, хамрах хүрээг өргөжүүлэхэд анхаарч ажиллах.	БТСХ
13	Боловсролын салбарын сургалтын чанар, стандартыг бодлогын түвшинд сайжруулах, хүний хөгжлийг хангах чиглэлээр англи хэлний багш нарын тоог нийслэлийн хэмжээнд /500/ нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах тул холбогдох байгууллагатай уялдаатай ажиллах.	Боловсролын хэлтэс
14	Хяналтын камерын тоог нэмэгдүүлэх, нэгдсэн төв байгуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд тодруулж ажиллах.	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс
15	2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс хойш Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас хийсэн ажлуудын жагсаалтыг НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх.	ЗДТГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
16	Нийслэлийн Засаг даргын захирамжаар зохион байгуулагдах цэрэг, спортын “Дөл” тэмцээний бэлтгэлийг ханган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Цэргийн штаб, “Хангай” цогцолбор сургууль
17	Хот тохижилтын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэж эхлэхтэй холбогдуулан дүүргээс хүргүүлсэн судалгаа, хүсэлтийн дагуу холбогдож асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах.	ТХҮХ
18	2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарлаж “Фокус” бүлгийн уулзалтуудыг зохион байгуулсантай холбогдуулан Хамтран ажиллах гэрээ байгуулсныг албажуулан, ажлын төлөвлөгөө гаргах, уулзалтуудын үр дүнг нэгтгэх, хугацаа бага ажлуудыг яаралтай зохион байгуулахад бодлогын хэлтсүүд анхаарах.	ЗДТГ
19	Зам дагуу болон аж ахуйн нэгж, байгууллагуудын харьяанд байгаа самбаруудын мэдээллийг шинэчлэх ажлыг яаралтай зохион байгуулах.	Холбогдох байгууллагууд
20	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан зөрчил дутагдлыг арилгуулж ажиллах.	Ажлын хэсэг
21	Малын сэг зэм устгах ажлыг зохион байгуулахад холбогдох тооцоолол, байршлыг гарган захирамжийн төсөл боловсруулан батлуулах.	ХААТ, МЭТ
22	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжийн дагуу Хаврын их цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн ажиллах.	ТХҮХ, Хороод, ААНБ-ууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР